



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Ажил дүгнэх журам,  
үзүүлэлт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын зургадугаар бүлгийн 6.1 дэх хэсгийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журам, үзүүлэлтийг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (С.Цэдэндамба)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦОГОО

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг.Зорилго

1.1.Энэхүү журмын зорилго нь: Төрийн албаны тухай хууль, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам", төрийн албаны стандартыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлын зорилт

2.1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах

2.2. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны явц, үр дүнг үнэлэх

2.3.Салбар зөвлөлөөр дамжуулан төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын эцсийн үр дүнд чиглэсэн үүрэг хариуцлага, мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Гурав.Хамрах хүрээ, дүгнэх үйл ажиллагаа

3.1.Дүгнэх үйл ажиллагаанд яам, агентлаг, аймаг нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд /цаашид "Салбар зөвлөл" гэх/ хамрагдана.

3.2.Салбар зөвлөлүүдийн тухайн жилийн үйл ажиллагааны тайлан болон тайлагнасан үйл ажиллагааг баримтжуулсан байдалд үндэслэн ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу Ажлын албаны даргын тушаалаар томилогдсон үнэлгээний комисс үнэлж дүгнэнэ.

Дөрөв. Үнэлж, дүгнэх аргачлал

4.1. Салбар зөвлөл нь "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт"-ийн дагуу үйл ажиллагааны тайлан бичиж, эхний хагас жилийн явцын тайланг 07 дугаар сарын 01-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн байна.

4.2.Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба нь Салбар зөвлөлүүдийн эхний хагас жилийн үйл ажиллагааны явцын тайланг нэгтгэн 07 дугаар сарын 30-ны дотор Зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

4.3.Салбар зөвлөлөөс ирүүлсэн тухайн жилийн үйл ажиллагааны тайлан болон тайлагнасан үйл ажиллагааг баримтжуулсан байдалд тулгуурлан чиг үүргийн хэрэгжилт, үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтийн үр дүнд шинжилгээ хийж, үнэлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Салбар зөвлөлийн үйл ажиллагааг газар дээр нь үнэлгээ хийнэ.

4.4.Ажил дүгнэх үзүүлэлтэд тусгагдсан үйл ажиллагааг 0-15 оноогоор үнэлнэ. /Тухайн ажил, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн бол авбал зохих оноог 100 хувь, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлсэн боловч тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй бол авбал зохих онооны 80 хувийг, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх

бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, тодорхой ажил, үйлчилгээ хийгдэж эхэлсэн бол авбал зохих онооны 50 хувийг, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж байгаа бол авбал зохих онооны 30 хувийг, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол авбал зохих онооны 10 хувийг, тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо "0" оноогоор тус тус үнэлнэ/

4.5. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор тухайн салбар зөвлөлийн авсан нийт оноог авбал зохих нийт оноонд харьцуулан, хувьд шилжүүлж дүгнэнэ.

4.6. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн үнэлгээг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шагнаж урамшуулах, ажлын хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэнэ.

4.7. Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг яам, агентлаг, аймаг нийслэл дэх салбар зөвлөл гэж 3 ангилан дүгнэх бөгөөд ангилал бүрээс хамгийн өндөр оноотой эхний 2 салбар зөвлөлийг шалгаруулж "Батламж", мөнгөн шагналаар урамшуулна.

4.8. Тухайн жилийн ажлаар 60 буюу түүнээс доош хувьтай дүгнэгдсэн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах саналаа томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

4.9. Тэргүүний үйл ажиллагаатай салбар зөвлөлийн дэвшилтэт арга барилыг бусад салбар зөвлөлүүдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба зохион байгуулна.

4.10. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь 60 буюу түүнээс доош хувьтай дүгнэгдсэн Салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, жигдрүүлэх асуудлаар үүрэг чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд шалган, туслах, арга зүйн зөвлөгөө өгч, ажил сайжруулах хугацаатай үүрэг өгнө.

4.11. Салбар зөвлөлийн үйл ажиллагаа нь 60 буюу түүнээс доош хувьтай дүгнэгдсэн салбар зөвлөлийн даргын сонголыг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



